



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот


Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх,
тайлагнах журам батлах тухай

Эрүүл Мэндийн Сайдын 2023 оны А/67 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг үндэслэн
ТУШААХ НЬ:

1. Тус төв нь эмнэлгийн эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журмыг 1 дүгээр хавсралтаар, эмийн гаж нөлөөг мэдээлэх хуудсыг 2 дугаар хавсралтаар, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл явцын зураглалыг 3 дугаар хавсралтаар, эмийн гаж нөлөөний зэргийг үнэлэх шалгуурыг 4 дүгээр хавсралтаар, эмийн сангийн гаж нөлөөний тохиолдлын мэдээний сангийн загварыг 5 хавсралтаар, дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эм зүйн албаны дарга (Э.Болорцэцэг)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ц.УРАНЧИМЭГ

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
2024 оны 02 дугаар сарын 01 өдрийн
А/39 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь эмийн гаж нөлөө болон эмийн хэрэглээтэй холбоотой үүссэн аюулгүй байдлын мэдээллийг бүртгэх мэдээлэх үйл ажиллагаанд эмнэлгийн мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн, мэдээлэх үйл ажиллагааг тогтмолжуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

АӨСҮТөв эмнэлгийн хэмжээнд дагаж мөрдөнө.

Гурав. Эмнэлэгт эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх

3.1. Эмнэлэгт илэрсэн эмийн гаж нөлөөг тушаалын гуравдугаар хавсралтад заасан урсгалын дагуу зохион байгуулна.

3.2. Үйлчлүүлэгчид тохиолдсон эмийн гаж нөлөөний дараах тохиолдлуудыг бүртгэж мэдээлнэ.

3.2.1. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацааг уртасгасан

3.2.2. Эмчилгээ оношлогоо шаардагдахад хүргэсэн

3.2.3. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд хүргэсэн

3.2.4. Хөгжлийн бэрхшээл, хөдөлмөрийн чадвар алдахад хүргэсэн

3.2.5. Амь насанд эрсдэл учруулж, эрчимт эмчилгээ хийлгэхэд хүргэсэн

3.2.6. Гаж нөлөөний улмаас нас барсан тохиолдолд бүрийг

3.2.7. Өндөр настанд (65-аас дээш нас) тохиолдсон гаж нөлөөний тохиолдолыг

3.2.8. Эмийн гаж нөлөө гэж сэжиглэсэн, мэдээлэх шаардлагатай гэж үзсэн бүх тохиолдлыг мэдээлнэ.

3.3. Үйлчлүүлэгчид тохиолдсон гаж нөлөө, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг анх илрүүлсэн эмч, ажилтан утсаар болон биечлэн эмчлэгч эмч, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан менежерт мэдээлнэ.

3.4. Эмчлэгч эмч эмийн гаж нөлөө болон эмийн хэрэглээтэй холбоотой үүссэн аюулгүй байдлын тохиолдлын огноо, гаж нөлөө үүсгэсэн сэжигтэй эмийн нэр, хэлбэр цуврал, тун хэмжээ, хэрэглэсэн арга, эмийг зогсоосон огноо, цаг минут, гаж нөлөөний эмнэлзүйн шинж тэмдэг, хүнд хөнгөний зэрэг авсан арга хэмжээ, эмчилгээ, оношлогоо ба шинжилгээний үр дүн, дүгнэлт болон гаж нөлөөний төгсгөлийг эмчлүүлэгчийн өвчний түүх болон картад бичиж тэмдэглэнэ.

3.5. Эмч, ажилтан нь эмийн гаж нөлөөний болон эмийн хэрэглээтэй холбоотой үүссэн аюулгүй байдлын мэдээллийг ЭЭХХЗГ-ын цахим хуудсанд (www.mmra.gov.mn) байршуулсан гаж нөлөө мэдээлэх цэсээр нэвтрэн хоёрдугаар хавсралтанд заасан маягтын дагуу шивж (gajnoloo@mmra.gov.mn) имэйлээр эсвэл иРепортинг (eReporting) системийн (<https://primaryreportong.who-umc.org/MN>) нэвтрэх холбоос ба QR код ашиглан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (цаашид ЭЭХХЗГ)-т цахимаар мэдүүлнэ.

3.6. Эмнэлэг нь эмийн гаж нөлөөний мэдээлэл цуглуулах шар хайрцагийг 3.5-д заасан иРепортинг системийн мэдээлэл болон хоёрдугаар хавсралтанд заасан гаж нөлөөний хуудасны хамт нүдэнд харагдахуйц ил байршуулна.

3.7. Хариуцсан мэргэжилтэн хоёрдугаар хавсралтад заасан шалгуурын дагуу үнэлгээ хийж эм, дархлаажуулах бэлдмэл хэрэглэснээр эмнэлэгт хэвтэх, эмнэлэгт хэвтэх хугацааг уртасгах, төрөлхийн болон байнгын хөгжлийн бэрхшээл үүсгэх, амь насанд эрсдэл учруулахуйц, үхэлд хүрэх хэмжээний аюултай гаж нөлөө болох ноцтой (V-VII түвшний), хүнд хэлбэрийн болох (III-IV түвшний) тохиолдлыг эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороогоор хэлэлцүүлэн, эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.7.1. Хүнд хэлбэрийн гаж нөлөөний (III-IV түвшин) тохиолдлыг ажлын 5 хоногт, ноцтой гаж нөлөө (V-VII түвшин)-г 24 цагт багтаана

3.7.2. Ноцтой, хүнд хэлбэрээс бусад гаж нөлөөний тохиолдлыг ажлын 10 хоногт багтаан ЭЭХХЗГ-т илгээнэ.

3.8. Эмийн эмчилгээг зохицуулах хороо болон эм зүйч нь тавдугаар хавсралтад заасан “Гаж нөлөөний тохиолдлын сан” -ийн тайлан болон Хүний эмийн зөвлөл, ЭЭХХЗГ-аас гаж нөлөөний мэдээллийн дагуу ирүүлсэн сэрэмжлүүлэг,

зөвлөмж шийдвэр, мэдэгдлийг тухай бүр эмнэлгийн нийт эмч, ажилтанд эргэн мэдээлж, уг шийдвэрийн дагуу авсан арга хэмжээг зохион байгуулах ажлыг гүйцэтгэнэ.

Дөрөв. Сургалт, мэдээлэл


4.1. Эмнэлэгт эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл, сургалтыг эмч, ажилтан эмнэлгийн мэргэжилтэнүүдэд тогтмол хийх .

4.2 Түгээмэл бүртгэгдэж байгаа эмийн гаж нөлөөг эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдэд цаг алдалгүй хүргэх, анхааруулах

4.3 Эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл сургалтыг ирэгдэд мэдээлэл сургалт хийх

4.4 ЭЭХХЗГ-с зохион байгуулж байгаа эмийн гаж нөлөөний аян сургалт, мэдээллээр хангах аливаа арга хэмжээнд хамтран оролцох.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
2024 оны 10 дугаар сарын 01 өдрийн
4/39 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ГАЖ НӨЛӨӨ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

Гаж нөлөөний хуудас бөглөх, мэдээлэх заавар:

- ✓ Эмийн гаж нөлөөний мэдээллийн дагуу шаардлагатай тохиолдолд зохицуулалтын арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэх нь урьдчилан сэргийлэх ач холбогдолтой тул та мэдээллээ цаг алдалгүй хариуцсан мэргэжилтэнд өгнө үү.
- ✓ Хуудсанд багтсан бүх мэдээлэл нь гаж нөлөөг мэдээллийг үнэлэхэд чухал асуултууд тул үнэн зөв, бүрэн бөглөнө үү.
- ✓ Гаж нөлөөний хуудсыг үнэлэх явцад дахин тодруулга хийх, эргэн мэдээлэл хийх шаардлагатай тул та өөрийн мэдээллээ бүрэн бөглөнө үү.
- ✓ Гаж нөлөөний тохиолдол илэрсэн эмчлүүлэгч болон мэдээлэгчийн нууцлалыг чанд хадгална.
- ✓ ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨНИЙ ТАЛААР МЭДЭЭЛСЭН ТАНЫ МЭДЭЭЛЭЛ БҮР ҮНЭ ЦЭНТЭЙ

1. ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Эмчлүүлэгчийн овог, нэр:

Төрсөн он, сар, өдөр.....

Нас

Хүйс:

Биеийн жин:

Өндөр....

☐ Эрэгтэй.

☐ Эмэгтэй

Эмчлүүлэгчийн онцлог:

☐ Жирэмсэн

☐ Хөхүүл

☐ Бусад

Урьд өмнө гаж нөлөө илэрч байсан эмийн нэр:

☐ Байхгүй

II. ГАЖ НӨЛӨӨ ҮЗҮҮЛСЭН ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ

Гаж нөлөө үзүүлсэн эмийн олон улсын нэршил:

Худалдааны нэршил:

Савлалтын тун:

Хүчинтэй хугацаа:

Эм үйлдвэрлэгчийн нэр:

Цувралын дугаар:

Улс:

Эмийн хэлбэр:

☐ шахмал

☐ капсул

☐ тарилга

☐ судсаар сэлбэх шингэн

☐ бусад:

Эм хэрэглэж эхэлсэн огноо: он сар

..... өдөр цаг минут

Эм хэрэглэхийг зогсоосон огноо: он

..... сар өдөр цаг минут

Эм хэрэглэсэн заалт /онош/:

Нэг удаа хэрэглэсэн тун:

Хоногт хэрэглэсэн тун:

III. ГАЖ НӨЛӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ:

Гаж нөлөө эхэлсэн огноо.....

цаг минут.....

Илэрсэн гаж нөлөөний шинж тэмдгийг дэлгэрэнгүй бичнэ үү!

Гаж нөлөө илэрсэн үед авсан арга хэмжээ:

- | | | | |
|--|--|--|--|
| ☐ Эмийн хэрэглээг зогсоосон | ☐ Эмийн тунг бууруулсан | ☐ Эмийг сольсон | ☐ Хийсэн эмчилгээ (нэр, тунг бичнэ үү!) |
|--|--|--|--|

Гаж нөлөө илэрсэн эмийн хэрэглээг зогсооход гарсан өөрчлөлт:

- | | | |
|--|---|---|
| ☐ Шинж тэмдэг арилсан | ☐ Шинж тэмдэг үргэлжилж байгаа | ☐ Шинж тэмдэг даамжирсан |
|--|---|---|

Гаж нөлөөний төгсгөл:

- | | | |
|---|---|--|
| ☐ Эдгэрсэн | ☐ Үргэлжилж буй | ☐ Эмнэлэгт хэвтэх хугацааг уртасгасан |
| ☐ Эрчимт эмчилгээ хийсэн | ☐ Хөгжлийн бэрхшээл үүссэн | ☐ Нас барсан |

IV. Хамт хэрэглэсэн эмийн мэдээлэл

№	Худалдааны нэр	Олон улсын нэр	Хэлбэр	Савлалтын тун	Нэг удаагийн тун	Хэрэглэсэн хугацаа
1						
2						
3						

Мэдээлсэн хүний нэр:

Утас:

И-мэйл хаяг:

Эмнэлэг, тасаг:

Мэргэжил:

Мэдээлсэн онгоо:

МЭДЭЭЛЭЛ ИЛГЭЭХ ХАЯГ:

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Шуудангийн хаяг:

UBH center, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, 14210
Утас: 51-26011



Мэйл хаяг:

gajnoloo@mmra.gov.mn

Цахим хуудас:

www.mmra.gov.mn

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
2024 оны 10 дугар сарын 07 өдрийн
А/29 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
2024 оны 10 дугаар сарын 01 өдрийн
11/29 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨНИЙ ХҮНД, ХӨНГӨНИЙ ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Хүнд, хөнгөний зэрэг багаас их рүү	Шалгуур үзүүлэлт
Түвшин 1	- Эмийн гаж нөлөө илэрсэн - Эмчилгээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй
Түвшин 2	- Гаж нөлөө үүсгэсэн сэжигтэй эмийг зогсоох, тунг өөрчлөх болон эмийг солих шаардлагатай - Илэрсэн гаж нөлөөнд эмчилгээ шаардлагагүй - Эмнэлэгт эмчлүүлэх хугацааг уртасгаагүй
Түвшин 3	- Гаж нөлөө үүсгэсэн сэжигтэй эмийг зогсоох, тун эсвэл эмийг солих шаардлагатай - Илэрсэн гаж нөлөөг эмчлэх шаардлагатай - Эмнэлэгт эмчлүүлэх хугацааг уртасгаагүй
Түвшин 4	- Гаж нөлөө үүсгэсэн сэжигтэй эмийг зогсоох, тун эсвэл эмийг солих шаардлагатай - Илэрсэн гаж нөлөөг эмчлэх шаардлагатай - Эмнэлэгт хэвтэх хугацааг 1 хоногоор уртасгасан
Түвшин 5	- Гаж нөлөө үүсгэсэн сэжигтэй эмийг зогсоох, тун эсвэл эмийг солих шаардлагатай - Эрчимт эмчилгээ шаардлагатай
Түвшин 6	- Эмийн гаж нөлөө нь үйлчлүүлэгчид байнгын хохирол буюу хөгжлийн бэрхшээл учруулсан
Түвшин 7	- Эмийн гаж нөлөөний улмаас шууд буюу шууд бусаар өвчтөн нас барахад хүргэсэн

н судлалын үндэсний тө
ны 10 дугаар сарын 01...өд
ушаалын тавдугаар хавс

Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан болон эм ханган нийлүүлэх гаж нөлөөний тохиолдлын мэдээний сан

[illegible]